

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мөнхбаяр	Дугаар	Л175
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Бигэр
Төрсөн газар	Бигэр	Төрсөн он	
Ажил мэргэжил	Байгаль орчны улсын байцаагч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бигэр номун ханы хүрээ, Соодын дацан	Сүм хийдийн дугаар	ГАБГ 096,
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Бигэр сумын Соодын дацан, Бигэр номун хааны хүрээ

Асуулт:-Тус сумын нутагт орших Бигэр номун ханы хийд болон Соодын дацангийн тухай бидэнд ярьж өгнө үү.

Хариулт:-Бигэр сумын нутаг дээр **Соодын** дацан, Бигэр номун хааны хүрээ зэрэг хийдүүд байгуулагдан ажиллаж байсан байгаа юм, дээр үедээ. Бигэр номун хааны хийдэд сууж байсан, хожим Говь-Алтай аймгийн Дашпэлжээ хийдийн хамба лам болсон Ивээ Хайнзан, хийдэд сууж байсан Жамбал, Соодын дацанд сууж байсан Дашзэвэг нарын дурсамжаас ярьж өгье.

Соодын дацан нь орон нутагтаа Хүүхэн **хутагтыг** залж ирээд, зүүн Сэрхийн нуруун дээрээс чулуу шидүүлэхэд шидсэн чулуу нь Жаргалант хэмээх бүлгийн ойролцоо унасан тул тэнд **Соодын** хийдийг байгуулсан гэдэг яриа байдаг. **Соодын** дацан гээд нэрлэдэг. Тус хийдийн тэргүүн Жамбал гэдэг хүн эрдэм номд төгс боловсорсон хүн байсан. Тэр нь болохоор Засагт ханд багшилж байсан хүн гэдэг. Тэгээд Нийслэл хүрээнд очиход нь баруун аймгийн номын хэнхэг иржээ гэж **шуугидаг** ийм домог яриатай байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энэ **Соодын дацангийн нэр** нь болохоор Дашпэлжээ гэдэг Цогчэн дуган, **гүнрэгийн** дуган, Дарь эхийн дуган, Нандин шүтээн гэсэн дугануудтай. Улаан сахиус, улаан ядам тахилгатай байжээ. Дацанд барагцаалбал 100 гаруй лам суудаг, **Цагдуултай** голын эхээс баруун урд уулнаас мөргөлчид ирж мөргөдөг байсан байна лээ. Тус хийдийн орчим газар нь **аравнайлагдсан** тул түүний ойролцоо Бигэр сумын төвийг сонгон байршуулсан түүхтэй.

Бигэр номун хааны хүрээний тухай ярья. Сумын төвөөс хойш 18 км-ийн зайд Бурхан буудай уулын зүүн **сугаас** доош дэрсний хаяан дээр Бигэр номун хааны хүрээний туурь байдаг. Үүрд гайхамшигт сүм гэсэн нэртэй. Олон гудамжтай, хашаа, худагтай тийм газар байсан. Одоо туурь нь байдаг. Дамбийжаагийн дээрэмчид тус сумын нутгаар дайран өнгөрөхдөө тус хүрээг дээрэмдэж, ном шүтээнийг нь Бигэр **номуны** ард талд байрлах толгод дотор булж, заримыг нь **Явар** нуур луу хийсэн гэдэг. **Явар** нь хүн орох аргагүй тийм их хэцүү газар байдаг. Хүн орохын ч хэрэггүй гэлцдэг. Одоо тус хүрээний туурийн үлдэгдэл шавар хэрэмнүүд байдаг. Засагт хан аймгийн Тамгатай **хутагтын** шавийн нэг болох Бигэр номун хааны хутагт нь бусад тамгатай хутагтуудын нэгэн адил хошуу захирах эрхтэй байсан. Аймгийнхаа чуулганд захирагдаж байсан онцлогтой юм.

Бигэр номын хааны үүх түүхийг **тодорхой** сурвалжлан бичсэн дэвтэр Улсын төв номын санд хадгалагдаж байдаг. Тэрхүү дэвтэрт бичсэнээр бол Бигэр номун хааны эхний гурван хувилгаан бол Энэтхэг, Төвдийн оронд хувилан төрсөн тухай өгүүлсэн байдаг. Энэтхэгийн оронд **Пагха** лам хэмээх анхны хувилгаан номун хан гарч, түүний хойно Төвдийн оронд **Лодойжанцан, Чоголжанцан** хэмээх 2, 3-р үеийн хувилгаан гарсан байдаг. Халх монголын анхны номун хаан хувилгаан **Лувсангалсанг** Чин улсын **айлтавын** 11-р онд Засагт хан аймагт Тэнгэрийг тэтгэсний 11-р онд баруун Богдоос ирсэн Дайчин хамба номун хаан, Эрдэнэт хаан ширээт цол олгосон байдаг.

Бигэр номун хаан **хутагтын** хийд том том хурлууд хурдаг байсан талаар архивын сурвалжид дурьдсан байдаг. Номун хаан шавийн **Чанцуу** Дэмбэрэлээс манай харьяат **хутагтын** анхны номун хан Лувсанданзангийн үед тэнгэрийг тэтгэсний 28-р онд нэгэн хийд байгуулан Цогчэн хурлын сургууль тогтоосон байсан. Тэнгэрийг тэтгэсний 54-р он буюу 1789 онд 2-р номун хутагт **Лувсанжалцангийн** үед Мөнх, **Нөөнөө, Сондуу, Дэмчиг чогийн** хурал тогтоосон байсан.

Номун хааны шавь нь **Цагдуултайн** голоос хойшхи нутгийг харьяалж байсан байна. 12 дугантай байсан, 2 нь том, бусад нь жижгэвтэр байсан байна. Эхний том нь Чойрын дуган, Домын баа, **Гавжийн** дамжаа, **Цанид**, Чойрын ном хурдаг. 2 дахь том дуганд нь 10 **Хангал**, магтаал хурдаг байсан байна. Харин 10 жижиг дуганд **дараахь** хурлууд хурж байжээ.

1. Дүйнхэрийн дуганд **Дүйнхор** хурж, **жинхар** бүтээнэ.
2. Гүнрэгийн дуганд **гүнрэгийн** сухайг хурна
3. Майдарын дуганд **Майдарыг** чого хурж, зуны адаг сарын шинийн 2-нд **Майдар** эргэдэг байсан байна.
4. Сундуйн дуганд **Сундуйн чого** хурна
5. Дэмчигийн дуганд дэмчигийн **чого** хурна

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

6. **Жидарын** дуганд **жидарын чого** хурна

7. Мэндэхийн дуганд мэндэхийн **чого** хурна

8. **Хажидийн** дуганд хажидийн чого хурна

9. Маналын дуганд маналын **чого** хурна

10. **Донжидийн** дуганд **лхам** бурхан, **Жамсран**, 5 хаадыг тахидаг байжээ.

Өвлийн адаг сард **хангал**, хаврын эхэн сард магтаал, зуны адаг сард **Ганжуур** хурдаг. **Жүдийг** тогтмол хурдаг байсан байна. Хийдийн хамба, ловон лам, да лам, **гэсгүй** лам, үнзад тэргүүтэн 300 гаруй лам байнга шавилан суудаг байжээ. Энэ хийдэд Түвшин, Дэмчиг, Далхаа, Тавхай, Ламжав зэрэг **үнзадуудтай** байжээ. Бигэр номун хааны хийд нь жасын Тамгын газартай. Тэндээ өргөл барьцаа зохицуулдаг. Жас хүрээд тусдаа мал сүрэгтэй байжээ.

Янжин хамба Чойжил гэдэг хүн хутагтад ном заасан гэдэг. Номун хааны хутагтад бараалхсан хэн боловч түүнтэй мэндлэхдээ үүрд гайхамшигт сүмийн хамба, Халхын Бигэр номун хаан, дайчин хамба, дархан **ширээт** хутагт ламын гэгээнтний тугтан амгалан үү гэж айлтгадаг байсан байна.

1918 оны тоо бүртгэлээр Бигэр номун хааны шавийн өрх нь 175 өрх, эр хүмүүс нь болохоор 461, үүнээс лам нь 200 гаруй, шавь 130, сул чөлөөтэй ард нь 19 байсан байна. Эмс охид нь 410. Бүгд 871 хүн ам 1918 оны тоогоор бүртгэгдсэн байна.

Номун хаан хутагт Ванчинсүрэн зөвхөн хувийн сандаа 130 толгой малтай, 18 оны тоогоор тоологдсон байна. Хийдийнх нь малын тоо бол 20 мянга орчим мал тоологдсон байсан байна. Бигэр номун хааны сүүлчийн хутагт нь 1920-иод оны эхээр өөрийн **хүрээнээ** сууж хурал номоо үргэлжлүүлсээр байсан гэдэг. Бигэр номун хааны хийдийг 1937 оны их хэлмэгдүүлэлтийн үед лам нарыг нь бариад тэгээд л үлдсэн лам нар нь болохоор хийдийнхээ эд хогшил, бурхан тахилыг 5 тэмээнд ачаад 3 удаа зөөсөн тийм сүраг ажиг яригддаг. Тэр газар нь болохоор хүн очихын аргагүй газар нуусан гэдэг. Одоо ч хүмүүс олоогүй тийм түүх яригддаг.

Бигэр номун хааны хийд нь одоогоор хурлын том дацан, байшин барилгын туурь л үлдсэн. **Соодын дацангийн** хувьд ерөөсөө үлдсэн юм бараг байхгүй, суурин дээр нь айл суурьшсан тийм байдалтай байдаг. Үлдсэн юм байхгүй.